

ХАМАГ МОНГОЛ БА ЗҮРЧИДИЙН АЛТАН УЛСЫН ХАРИЛЦААНЫ МӨН ЧАНАР

Ц. Батбаяр

Монголчууд 1206 онд нэгдсэн төр улсаа байгуулан Төв Азийн түүхийн тавцан дээр нэгэн их хүч болон түрэн гарч ирсэн билээ. Энэ нь монгол овог аймгуудын дотоод нийгмийн хөгжлийн чухал нэгэн үр дагавар болохоос гадна гадаад хүчин зүйлтэй ч холбоотой. Монголын овог аймгууд нь барагцаалбал XI—XII зууны заагт ураг төрлийн байгууллыг давж феодалын нийгмийн харилцаанд шилжих хөгжлийн шатнаа хүрч Хамаг Монгол нэртэй улсаа байгуулжээ. Хамаг Монгол улс сэргэн мандах, доройтон буурахын улирлыг ээлжлэн өнгөрүүлсээр XII зууныг шувтаргал оршин тогтносон түүхтэй.

XI—XII зууны Монголын нийгмийн үндсэн хэрэг явдал Хамаг Монгол улсын дотоод зөрчил, Хамаг Монгол ба бусад татаар, хэрэйд, найман зэрэг аймаг, ханлигийн хоорондын харилцаагаар шийдвэрлэгдэж байв. Иймээс ч Хамаг Монголын суурин дээр нийт эсгий туургатныг нэгтгэсэн тулгар төр тогтоох нь монголын нийгмийн хөгжлийн шаардлагаас урган гарсан түүхэн үйл явц байлаа.

Үүний зэрэгцээ 1115 онд төр улсаа байгуулан хүчирхэгжин гарч ирсэн зүрчид угсааны Алтан улс Монголын тулгар төр үүсэх явцад зохих нөлөө үзүүлснийг үгүйсгэх аргагүй. Алтан улс хятаны Ляо улсыг мөхөөж монгол овог аймгуудын их хөрш гүрний хувьд монголчуудын талаар идэвхтэй бодлого явуулж байжээ. Тэд Хамаг Монгол улсын сүр хүчийг хүлээн зөвшөөрч түүнтэй зохицох бодлого явуулахын хамт монгол аймаг, ханлигуудын хоорондын зөрчил тэмцлийг овжин ашиглаж хүчийг нь сулруулан эрхшээлдээ оруулж авахыг эрмэлзэж байв. Энэ бүгд нь эцсийн эцэст монгол овог аймгуудыг нэгдэн нягтарч нэгдсэн төр улсаа байгуулах түүхийн их урсгалд өөрийн эрхгүй түлхсэн гадаад хүчин зүйлийн нэг гэж үзвээс зохилтой.

Нэг. Хабул хааны үеийн Хамаг Монгол-Алтан улсын харилцаа

XII зууны эхэн үед язгуурын монгол аймгууд нь төр улсын шинж төлөвтэй болж «Хамаг Монгол» гэж түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Түүхч Д. Гонгорын бичсэнээр Хамаг Монголын нутаг нь Хангайн нуруу, Орхон, Туулын бэлчээрээс Халхын гол, Буйр, Хүлэн нуурын орчмоор савалж гол төв нь Бурхан Халдун уулын хавьд байжээ.¹

Хамаг Монголын анхны хаан нь Чингисийн элэнц эцэг. Тумбинай сэцэний ахмад хөвгүүн Хабул (1101-1148) болно. Хабул нь өөрийн харьяат иргэд, аймаг овгийнхоо тэргүүн эзэн байж бүх монголчууд дотор алдартай, нэр хүндтэй байжээ.² Монголын нууц товчоонд «Хамаг Монголыг Хабул хаан захирч байв»³ гэж товч тодорхой өгүүлсэн байдаг.

Хамаг Монгол болон зүрчидийн Алтан улсын хооронд идэвхтэй харилцаа XII зууны 30-аад оноос эхэлсэн гэж түүхчид үздэг. 1130-аад оны орчим зүрчид нар төр улсынхаа умард хязгаарт аль ч улсын харьяат биш иргэдийг дайчлан барьж тэдний чихийг цоолон улсын санд харьяалагдахыг илтгэсэн тэмдэг зүүж байжээ. Тэдгээр иргэдийн заримыг Алтан улс дотор худалдсанаас гадна нэг хэсгийг умард хил

дээр аваачиж мориор сольж байсан байна. Тэднийг худалдан авагчдын дунд монголчууд байсан ажээ.

Хятадын сурвалж бичигт: «Шао син төр барьсан үеэс (1131-1162) эхлэн «монголчууд» амар заяа үзүүлэхгүй болов. Бүх цэргийг хамаарагч Цзун-би хэдэн жилийн турш цэрэг илгээн дайтсан боловч тэднийг дарж чадсангүй. Иймд тэрээр цэргээ хуваан стратегийн чухал газрыг хамгаалалтдаа авав. Нөгөө талаас тэдэнд ихээхэн хээл хахууль өгчээ. Тэдний эзэн өөрийгөө цзуюань хуанди буюу «төр улсыг үндэслэгч-эзэн хаан» гэж нэрлэж байлаа»⁴ гэж бичжээ. Үүнээс үзвэл Хамаг Монгол, Алтан улсын эвдрэл хямрал 1130-аад оноос эхэлсэн байна. Үүнийг мөн Хятадын Жилин мужийн нутгаас олдсон зүрчид бичиг үсгийг зохиогч Ваньянь Сининьд зориулсан хөшөөний бичээс давхар гэрчилж байгаа юм. Уг хөшөөний бичигт «Мэнгусы (монголчууд—Ц. Б.) хил хязгаарыг түйвээж байсан учир ван тайши Цзун-панийн хамт эзэн хааны зарлигаар тэднийг залхаан цээрлүүлэхээр мордов» гэж бичжээ. Ван хэмээх нь зүрчидийн их бичгийг зохиож нэрд гарсан тухайн үедээ зүрчидийн тэргүүн зэргийн цэргийн жанжны нэг болох Ваньянь Сининь болно. Цзун-пан хэмээгч нь Алтан улсын хоёрдахь удаагийн хаан Үжимэйн их хөвгүүн бөгөөд 1139 онд нас нөгчих хүртлээ ордны шадар түшмэдийн нэг байжээ. Ваньянь Си Нинь нар монголчуудын эсрэг аянд чухам хэдийд мордсон бэ гэдэг нь туйлын анхаарал татсан асуудал юм. Японы зүрчид судлаач Тояма Гунжи уг хөшөөний бичээсийг нягтлан судалсны үндсэн дээр энэ нь 1135 оны 11 дүгээр сараас 1138 оны 7 дугаар сарын хооронд болсон үйл явдал гэсэн дүгнэлтэд хүрчээ.⁵

Ийнхүү 1130-аад оны дундуураас эхлэн 1147 он хүртэл үргэлжилсэн Хамаг Монгол болон Зүрчидийн хоорондын дайн байлдааны эх үүсвэр чухам юунд оршиж байв? Энэ тухай Рашид-ад-Дины «Судрын чуулганд» хэрхэн бичсэнийг үзье. Хамаг Монгол улс Хабул хааны үед хүчийг олж түүний тухай цуу чимээ Алтан улсад хүрчээ. «Алтан улсын хаан Хабул хааныг хүндэтгэвээс зохих хүн гэж үзэж түүнтэй ойр дотно болох, хоёр этгээд найрамдан нэгдэх уужим зам гаргахыг эрмэлзэж Хабул хааныг урин элч илгээжээ».⁶ Хабул хааны хүрч очиход Алтан улсын хаан «эрхэмлэн хичээнгүйлэх дүр байдал үзүүлэн» их найр хөл болж байсан байна. Хабул хаан будаалгын хоолоос хор олохыг сэргийлж байсан боловч, нэгэн өдөр ордны найран дээр санамсаргүй согтож Алтан хааны сахлыг шувтарч доромжилсон байна. Түүний сайд түшмэд Хабулыг алах хэмээсэнд Алтан хаан: Энэ болбоос ёсыг алдсан хэрэг, ял болсон бус хэмээн хэлтрүүлж, бэлэг сэлтийг өгч нутагт нь буцаажээ. Алтан хаан хэрвээ Хабулыг ийм үл ялих зүйлээс болж алах аваас түүний үр сад нь өшөө хорслоо авахаар босон хөдөлж тэдний хооронд дайн дажин үргэлжилж магад хэмээн болгоомжилж ийм алхам хийсэн байна. Дараагаар Алтан улсын сайд, түшмэд цөмөөр Хабулд муу санаа агуулж, өдгөө түүнийг арилгахгүй аваас хожим эрхбиш хор болно хэмээн ятгасанд Алтан хаан тэдний үгэнд орж, элч түшмэл томилон Хабулын хойноос нэхүүлэн илгээжээ. Хабул хаан Алтан улсын элчийг «Бидний хооронд ярилцах зөвшилцөх зүйл дууссан, бид (хааны соёрхлоор салсан...)»⁷ гэж хэлэн буцаасан байна. Гэвч Алтан улсын элч бас дахин ирсэнд Хабул хаан тэдний хорт санааг мэдээд төрөл садантайгаа хамсан Алтан улсын элчийг алсан байна. Энэ хэрэг явдал нь 1135—1147 он хүртэл үргэлжилсэн монгол зүрчидийн дайн байлдааны шалтгаан болсон гэж үзэх үндэстэй юм.

Алтан улсын элчийг аймшиггүй алж хороосон Хабулыг хашраахаар Алтан улсын хаан их цэрэг хөлөлгөн мордуулсан нь илэрхий. Энэ

тухай түүхч А. Амар: «Алтан улсын хаан өөрийн жанжин Ху Шаху хэмээхийг томилон цэрэг авахуулж байлдаар явуулсанд Ху Шаху Монголын хил өнгөрмөгц газрын байдал ба цэргийн арга бодлогыг мэдэхгүй, дэмий ийш тийш сүлжин явахад, Хабул хаан эрдэм ухвартай тул олноо дагуулан ууланд нуун далдалж, өдөр удтал нэг ч хүн үзэгдэхгүй болсонд Ху Шаху хүнс дутаж аргагүй хойш буцах гэтэл монгол цэрэг хөөн ирж байлдан, нэгэн бүлэг цэргийг алсанд Ху Шаху зугатав»⁸ гэж бичжээ. Зүрчидийн цэргийн жанжин Хушаху нэгэн түмэн цэргийг авч умар зүгт монголчуудын эсрэг дайтсан тухай «Да Цзинь го чжи» хэмээх сурвалж бичигт тэмдэглэгдэн үлдсэн байна. Уг сурвалжид Хушаху хүнс тэжээлээр гачигдан буцахад хүрсэн бөгөөд тэдний араас монголын цэрэг нэхэн Цзинь улсын дээд нийслэл Шанцзинээс баруун хойд зүгт орших Хайлин гэдэг газарт гүйцэн ирж тулалдан хүнд цохилт өгсөн хэмээжээ. Уг явдал чухам хэдийд болсон нь тодорхойгүй боловч түүхчдийн үзэж байгаагаар 1138 онд болсон бололтой.

Зүрчид нар хил хязгаараа бататган хамгаалахын тулд чжаотаосы нэртэй хил хязгаараа сэргийлэх байгууллагыг 1140 онд байгуулжээ. Нийт гурван чиглэлд байгуулснаас зүүн хойд чиглэлд Монгол болон Солонгосоос сэргийлэх, баруун өмнөд чиглэлд татаар болон тангадын Си Ся улсаас сэргийлэх зорилготой байв. Ху шахуг ялсан нь түр зуурын амжилт гэдгийг ойлгож байсан Хабул хаан агт морьдоо тэжээж, цэрэг эрсээ сурган Алтан улсад цэргийн хүчээр шийдвэртэй няцаалт өгөхөөр бэлтгэж байв. Энэ хэрэгт мөн Алтан улсаас дайжин ирсэн зүрчидийн түшмэд багагүй үүрэг гүйцэтгэж байжээ. Тухайлбал, цаазаар авахуулсан ордны зөвлөх Даланий хөвгүүн Шэн хуаду гэгч өөрийн албат иргэдээ дагуулан Хабул хаанд дагаар орж ирж монголчуудтай эвсэн Алтан улстай дайтаж байсан баримт бий.¹⁰

1140—1146 оны хооронд Хабул хаан Алтан улс лугаа эрс шийдвэртэй байлдаж Сипинхэ¹¹ голоос умард орших 27 цайзыг эзлэн авсан бололтой. Алтан улсын хаан 1141-42 оны орчим Сүн улстай найрамдаж, жанжин цэргээ татаж, гагцхүү хойд хязгаарын монголчууд тугаа нэжгээд удаа байлдсан боловч огт дийлсэнгүй. Түүхч А. Амарын бичсэнээр: «Харин эцэст цэрэг, морин ядарч, хэрэглэл дутагдан, бас ч Ху шахугийн адил болохоос болгоомжлон, найрамдлыг тогтоон, Шин Бингэбайгийн хорин долоон цайзыг цөмийг таслан өгч, жил бүр үлэмжхэн тоотой үхэр, хонь, аму өгөхөөр тогтон, бас Хабул хааныг Монгол улсын ван өргөмжилж, цэргээ зогсоон найрамджээ.¹²

1146—1147 оны орчим ийнхүү Хамаг Монгол Алтан улстай найрамдсаныг бидний дээр иш татсан «Да Цзинь го чжи» сурвалж ч мөн нотолж байна. Уг сурвалжид: «Цзинь улс хэдэн жилийн турш Монголчуудыг дарахыг оролдов. Хуантуны (1141—1149) 6-р оны найман сард Сяо Баошуг тэдэнтэй найрамдахаар явуулав. Тэрээр тэдэнд Сипин голоос умарш 27 цайзыг найр тавин өгсөн бөгөөд тэднээс жил бүр үхэр, хонь, амугаар алба авахаар болжээ. Тэдний аймгийн тэргүүн Аоло-боцзилег монголчуудын эрх баригчаар томилов. Үүний дараа Аоло-боцзиле өөрийгөө Цзуюань-хуанди хэмээн зарлаж төр барьсан оноо Тяньсин гэж нэрлэх болов. Цзинь хэдэн жилийн турш монголчуудтай тэмцсэн боловч тэднийг ялж чадсангүй»¹³ хэмээн өгүүлжээ.

Уг сурвалжид өгүүлсэн Аоло-боцзиле хэмээгч нь Хамаг Монголын хаан Хабул болох нь тодорхой. Тэрээр Алтан улсаас өргөмжлөх гэсэн ван цолоос татгалзаж өөрийгөө төрийг үндэслэгч эзэн хаанд (Цзуюань хуанди) өргөмжилсөн нь нарийн учиртай. Хабул хаан Хятадын хаадын нэр цолыг чамгүй мэддэг байсан нь илэрхий. Иймээс тэр өөрийн

төр барих он тооллын нэрийг тогтоож, улсын ван биш харин төр улсыг үндэслэгч эзэн хаан цол авчээ. Алтан улс ийнхүү найрамдаж буулт хийсэн явдал нь XII зууны дунд болоход Хамаг Монголын дотоод, гадаад байдал ихэд бэхжиж, Төв Азийн улс төрийн амьдралд мэдэгдэхүйц байр суурьтай болсныг харуулж байна.

Хоёр. Татаар-Монголын зөрчлийг Алтан улс ашигласан нь

Хамаг Монголын хаан Хабул нас өөд болохын цагт долоон хөвгүүнээ байсаар байтал тайчуудын Сэнгүн билгийн хөвүүн Амбагайг Хамаг Монголын хаан болгохоор хэлсэн гэж «Нууц Товчоо»-нд бичсэн байдаг. Ийнхүү Хабул хаан Хияд овгоос Тайчуудад төрийн эрхийг шилжүүлсний учир шалтгааныг судар түүхэнд тэмдэглэсэнгүй. Хабулын долоон хөвгүүд дотроос хоёрдугаар хөвгүүн Бардан баатар, дөрөвдүгээр хөвгүүн Хотула хан, зургадугаар хөвгүүн Хадаан баатар нар Хамаг Монголын төр-цэргийн том зүтгэлтэн нар болжээ. Амбагай хаан төрийн зохион байгуулалтанд өөрчлөлт оруулж «тайш» гэдэг голдуу цэргийн хэргийг эрхэлсэн хааны удаагийн тушаалыг бий болгов. Амбагайн үед улсын тайш нь түүний дунд хөвгүүн Хадаан байжээ.

XII зууны туршид Хамаг Монгол, Татаар, Мэргэд, Хэрэйд, Найман зэрэг том аймаг, ханлигууд нь найртай зэрэгцэн оршихын хамт хоорондоо хямралдан тэмцэх нь олонтаа байлаа. Тэрхүү дайн дажны гол шалтгаан нь овог аймгийн тэргүүн нар адуу мал, албат боол, бэлчээр ус булаацалдан өвөр хоорондоо эрх мэдлээ бэхжүүлэхийн төлөө өрсөлдөөн тэмцэл байсан нь магад. Үүнээс гадна гадаад хүчин зүйл ч байжээ. «Нууц-товчоо»-нд бичсэнээр Буйр Хөлөн хоёр нуурыг холбож урсах Оршуун мөрний хөвөөгөөр татаар аймаг нутагтаж байлаа. Татаар аймгийн нутаг чухамхүү Найман, Хэрэйд, Мэргэд мэтийн ханлигууд өмнө зүгийн хөрш оронтой харилцах замд хөндөлсөн оршиж стратегийн байр эзэлж байв. Энэхүү татаар аймаг XII зууны дунд үеэр сүр хүчээ зузаатгасан Алтан улсын эрхшээл нөлөөнд автаж монгол аймгуудынхаа эсрэг чиглэсэн үйл ажиллагаа явуулж байсан нь монгол аймгууд хоорондоо дайсагналцах нэгэн түлхээс болж байжээ.

1130-аад онд Хабул хаан Алтан улсын элчийг хороосноос болж Хамаг Монгол, Алтан улсын харилцаа хурцдахын хамт татаарууд Алтан улсын өдлөгөөр Хабул хааны ахмад хөвгүүн Охинбархагийг гэнэдүүлэн баривчилж Алтан улсад хүргүүлэн модон илжигэнд засаглуулан, алуулжээ.¹⁴ Эл хэргээс үүдэн Хамаг Монгол, Татаарын хооронд цусан өшөө авахын төлөө урт ужиг тэмцэл эхэлсэн бүлгээ. Охинбархагийн өшөөг түүний дүү Хамаг Монголын Хадаан баатар тэргүүлэн нэхэж Татаартай есөн удаа хүртэл дайлалдаж явсан байна. Гэвч татаарыг сөгдүүлэн буулгаж авч чадсангүй ажээ. Уул тэмцэл XII зууны дунд үе хүртэл үргэлжилж Хамаг Монголын Амбагай хааны үед дахин шинээр хурцадсан байна.

Тэр үед Хабул хааны эхнэрийн дүү Сайн-тэгин хэмээгч гэнэт өвчин хүрч, татаар аймгаас нэгэн бөө урьж үзүүлээд засралыг олсонгүй үхсэнд Сайн-тэгиний төрөл садан тэрхүү бөөг алсан байна. Үүнд татарууд өшөө авахаар цэрэг мордуулж байлдахаар ирсэнд Хабул хааны хөвгүүн Хадаан баатар удаа дараа байлдан тэдний Мэнэн баатарыг жадлан алсанд 15 татаар нар далдуур хорсовч ил найрамдахыг бодолхийлж уран үг, эд бэлгээр Амбагай хааныг хуурав. Энэ тухай «Нууц товчоо»-нд: «Тэдэнд Амбагай хаан охиноо өгч, өөрөө охиныг хүргэж очоод татаарт баригдав. Татаар, Амбагай хааныг барьж Хятадын Алтан хаанд хүргүүлэв. Бэсүд овгийн Балхачи гэдэг хүнийг элч

болгож Амбагай хааны хэлүүлсэн нь: «Хабул хааны долоон хөвүүний дундахь Хоталад, миний арван хөвүүний дундахь Хадаан тайшид чи очиж хэл. Хамгийн хаан, улсын эзэн байтал охиноо өөрөө үзэж хүргэхийг надаар цээрлэл болгогтун! Би татаар аймагт баригдав. Таван хурууны хумсыг тамтартал, арван хуруугаа барагдтал миний өшөөг авахыг оролдугтан» гэж илгээжээ»¹⁶ хэмээн өгүүлсэн байдаг.

Рашид-ад-Дины бичсэнээр Хамаг Монголын хаан Амбагай ургийн хэргээр очиход нь татаарууд түүнийг гэнэдүүлэн барьж Алтан улсад хүргүүлж Охинбархагийн адил модон илжигт хадуулан алуулсан байна. Амбагайг цаазаар авахын өмнө тэрээр өөрийн нэгэн нөхөр Булгачийг («Нууц Товчоо»-нд Балхачи хэмээжээ). Алтан хаанд илгээж: «Чи намайг өөрийн эр зориг, сүр хүч, цэргээр дагуулаагүй, харин хөндлөнгийн хүмүүс намайг барьж чамд авчирсан билээ. Чи миний амийг ийм жигшүүртэй, хөөрхийлөлтэй байдалд бүрэлгэснээр Хадаан тайш, Хотула хан, Тодой отчигин, Монголын овог, аймгийн тэргүүн нарыг өөрийн дайснаа болгож дайсагнал төрүүлж байна. Тэд миний цусан өшөө авахаар босож ирэх нь эргэлзээгүй, иймээс намайг алах нь ухаангүй хэрэг» гэжээ. Үүний хариуд Алтан хаан: «Чи надад ийм мэдээ хүргэж ирсэн учир өөрөө явж эдгээр улсдаа хэл хүргэ!» хэмээн үл тоосон, ихэмсэг байдал гаргажээ.¹⁷

Амбагай хааны захиасыг авсан Хадаан тайш, Тодой отчигин болон Есүгэй баатар нар монголын овог аймгийн тэргүүн нарыг цуглуулан их хурилдай хуруулж Амбагай хааны цусан өшөөг авахаар шийджээ. Хотулыг Хамаг Монголын хаанд залж, түүнд бүх цэргийг захируулан өмнө зүг мордов. Алтан улсын цэрэгтэй тулалдан бутцохиж, олон тооны зүрчид нарыг алж хядан дээрэм тонуул хийжээ. Булаан авсан их хэмжээний олзыг цэрэгтээ хуваан өгсний дараа нутгийн зүг буцсан гэж «Судрын чуулганд» өгүүлжээ.¹⁸

Монголын нууц товчоонд «Амбагай хаан баригдаад Хадаан, Хотула хоёрыг нэр заасан тул хамаг монгол, тайчууд нар Онон мөрний Хорхунагийн хөндий гэдэг газар цугларч хэлцээд Хотулыг хаан болгов. Хотула хаан болоод Хадаан тайштай хоёулаа татаар иргэнээс өшөө авахаар мордов. Татаарын Хотан бараг, Жали буха хоёртой арван гурван удаа байлдавч. Амбагай хааны өшөөг сайтар авч эс чадав»¹⁹ хэмээн тэмдэглэсэн байдаг.

Монгол, татарын олон жил үргэлжилсэн ужиг тэмцлийг зөвхөн овог аймгийн өшөө атаархлын илэрхийлэл гэж үзвээс учир дутагдатай. Үүнд эдийн засаг, улс төрийн учир шалтгаан давамгайлж байсан бололтой. Татаарын нутаг, тухайлбал, Хөлөн, Буйр хоёр нуур орчмын нутаг нь мал сүрэг адуулан өсгөхөд туйлын таатай үржил шимтэй бэлчээр нутаг байжээ. Тэрхүү бэлчээрийг эзэмшихийн төлөө монголын овог аймгууд өрсөлдөн тэмцсэнээс дээр дурьдсан дайн тулааны нэлээд хэсэг үүссэн байж мэднэ.

«БНМАУ-ын түүхийн» тэргүүн ботид тэмдэглэсэнээр Хамаг Монгол, Хэрэйд, Мэргэд зэрэг аймгуудын дорно зүгтэй харилцах зам дээр нь татаарууд хөндөлдөн суусан байдал нь Дүнбэйд байгуулагдсан улсуудаас татааруудыг бусад монгол аймгуудын эсрэг харгалдуулан тавихад нь газарзүй, эдийн засаг, улс төрийн талаар дөхөм болжээ.²⁰

Хөрш орнуудын суурьшмал хүн амтай харилцах, эдийн засгийн солилцоогоо өргөжүүлэх гэсэн монгол аймгуудын ашиг сонирхол нь Алтан улсаас монголчуудыг бүх талаар хяхаж хавчиж байсан бодлоготой мөргөлджээ. Ийм зөрчлөөс үүдэн Хамаг Монгол, Алтан улсын хооронд дайсагналцах байдал олон арван жилээр үргэлжилсэн бөгөөд 2«За №25»

энэ нь татаар, монголчуудын хооронд 70—80 жил сунжирсан дайн байлдаанд ямар нэг хэлбэрээр тусгалаа олж байлаа.

Гурав. Тэмүжин Татаар аймгийг байлдан сөнөөсөн нь

Хабул хааны ууган хөвгүүн Бардан баатарын хөвгүүн Есүгэй баатар Хотула хааны дараа олонхи монгол аймгийг захирч байжээ. Тэрээр эцэг өвгөдийн өшөөг авахаар татаар аймагтай олон удаа байлдаж байсан бөгөөд нэгэн удаагийн байлдаанд татаарын тэргүүлэгч Тэмүжин-үгэ, Хори-буха нарыг барьж иржээ. Чухам тэр үед Өэлүн үжин Ононы Дэлүүн болдог гэдэг газар хүү төрүүлсэн бөгөөд татаарын Тэмүжин-үгэг барьж ирэх цагт тохиолдож төрөв гэж Тэмүжин нэрийг өгчээ.

Есүгэй баатар Тэмүжинийг есөн настай байхад Тэмүжин хөвгүүндээ бэр гуйхаар авч яваад Хонгирадын Дай сэцэнийд хөвгүүнээ хүргэн болгон үлдээж буцах замдаа татаарт хорлогдон нас нөгчсөн байна. Тэмүжин чухамхүү тэр үеэс «хагацсан улсаа хамтатгах, бутарсан улсаа буцаан хураах» тэмцлийг явуулсны дүнд 1189 онд Хамаг Монголын хаанд өргөмжлөгдөж «Чингис» цол хүртжээ.

Алтан улсын хаан Ши-цзүн төр барьж байсан 1161—1189 оны үед татаарууд үе үе Алтан улсад цэргийн хүчээр халдан ирдэг байсныг хятадын сурвалж бичигт өгүүлжээ. Алтан улсын хаан Ши-цзүн «татаарууд манай оронд гай тарьж мэднэ» хэмээн түгшүүртэй болж их цэрэг хөдөлгөн тэднийг устгахыг тушаасан байна. Тийнхүү 3 жил бүр нэг удаа цэрэг илгээн татаар нарыг хядахыг нь хядаж, хөвгүүдийг нь олзолж авчран боол болгож байсан гэж тэрхүү сурвалжид бичжээ.²¹ Энд бичсэн татаар гэдэг нь зөвхөн татаар аймгийг зааж байна уу, эсвэл бүх монголчуудыг төлөөлөн нэрлэж байна уу гэдэг нь тодорхой бус ажээ.

Гурван жил бүр нэг удаа Алтан улсын эрх баригчид цэрэг илгээж байсан тухайд гэвэл зөвхөн «Мэн-да бэй-лу»-гаас өөр «Цзиньши» мэт тэр үеийн бусад сурвалж бичигт энэ тухай огт дурьдсан үгүй байна. Харин тэдгээрт 1195, 1196, 1198 онд гурван удаа дараалан умарт этгээдэд цэрэг илгээсэн хэмээн өгүүлжээ. Үүний нэг 1196 онд Алтан улсын цэрэг татаар аймгийг байлдаар ирсэнд Чингис хаан хүч хавсран оролцсон билээ.

Энэ тухай «Нууц Товчоо»-нд: «Тэр цагт Хятадын Алтан хаан, Татаарын Мэгүжин сүүлтийг эедээ үл орох тул Вангин чансанд цэрэг өгч, тэдэнтэй даруй байлд гэж явуулжээ. Чингис хаан өгүүлрүүн: «Хэдийнээс Татаар бол бидний эцэг өвгөдийг алсан өстөн иргэн билээ. Одоо энэ алалдаанд хавсралцъя» гээд, Тоорил ханд элч зарж «Алтан хааны Вангин чансан, Мэгүжин-сүүлт тэргүүтэй татаарыг Улз өөд түрж айсуу гэнэ. Эцэг өвгөдийг хорлосон өшөөт татаартай байлдъя. Тоорил хан эцэг даруй иртүгэй» гэж явуулав»²² хэмээжээ. Ийнхүү Чингис хаан. Тоорил хан нар Улз өөд очин татаарыг бутцохиж, Мэгүжин сүүлтийг алж тэднээс үнэт эд зүйлийг олзлон авчээ.

Үүнд хамгийн сонирхолтой нь Мэгүжин сүүлтийг алав гэж Чингис хаан Тоорил хан хоёр мэдэгдвэл Вангин чансан сонсоод ихэд хөхөж Чингис хаанд чаутхури,²³ Хэрэйдийн Тоорилд ван цол шагнасан явдал юм. Вангин чансан мөн «Мэгүжин сүүлтийг хавсран алж, та нар Алтан хаанд их тус хийв. Энэ тусыг чинь Алтан хаанд хэлье би. Чингис хаанд үүнээс илүү цол шагнахыг Алтан хаан мэдтүгэй» хэмээсэн гэж «Нууц Товчоо»-нд бичжээ.

Тэмүжин ийнхүү 1196 онд Алтан улсад туслан хэрэйдийн хан Тоорилын хамт Татаар аймгийг байлдсан явдал түүний байр суурь бэхжихэд ихээхэн ашиг болов. Юуны өмнө тэрээр эрт үеэс өстэй хүчирхэг татаар аймгийг бусадтай хавсран цохиж доройтуулан хүчийг нь сулруулан айх аюулгүй болжээ. Нөгөө талаас Алтан улс татаар аймгийг эвсэн байлдаж хил хязгаарыг төвшитгэх хэрэгт тус болов гэж Тэмүжинд чаутхури цол шагнасан нь талын язгууртны дунд түүний нэр хүндийг улам дээшлүүлсэн бололтой.

Эцэст нь 1202 оны намар Чингис хаан Далан нэмүргэ гэдэг газар татаар аймагтай байлдаж тэднийг бүрмөсөн эзлэн дагуулсан түүхтэй. Татаарыг сөнөөж, бүгдийг эзэлсэн хойно улс иргэдийг нь яах тухай Чингис хаан алтан ургаа цуглуулж зөвлөлдөөд «эрт цагаас нааш эцэг өвгөдийг минь хорлосон энэ муусайн татаруудыг эгнэгт дуусгахын тул тэрэгний булд хэмжиж үгүй хийж дуусгая» гэж тогтсон тухай «Нууц Товчоо»-нд өгүүлсэн байдаг.²⁴ Үүнээс үзэхэд эртнээс нааш өстэй явж ирсэн татаар аймаг, тэднийг өдөөн хатгаж байсан Алтан улсыг сөнөөн мөхөөх санаа Чингис хааныг удаан хугацаанд эзэмдэж ирснийг харуулж байна. Сүүлд Алтан улсын эсрэг аян дайнд мордохын өмнө Чингис хаан «Хятадын эрх баригчид миний өвөг дээдэс Амбагай хаан, Охинбархаг болон Хадаан баатарыг алж тэднийг зэрлэгээр тамалсан учраас би тэдний өшөөг авахаар мордож буй бөгөөд эзэн тэнгэр минь туслан тэтгэх ажаамуу!»²⁵ хэмээн тангараг өргөж байсныг Рашид-ад-Дин тэмдэглэн үлдээжээ.

XII зууны үеийн Хамаг Монгол-Алтан улсын харилцаа ерөнхийдөө нэг талаас монголын олон овог аймгийг нэгтгэн зангидах гэсэн Хамаг Монголын хаадын удаа дараагийн хүчин чармайлт, нөгөө талаас нүүдэлчин аймгуудын хямрал тэмцлийг ашиглаж хүчийг нь сулруулах хэмээсэн Алтан улсын бодлогоор тодорхойлогдож байв. Төв Азид жанжлалаа тогтоож дангаар ноёрхох гэсэн Алтан улс Хамаг Монголын хүчийг сулруулахын тулд Хамаг Монгол-Татаарын хоорондын зөрчил тэмцлийг овжин ашиглаж байлаа. Хамаг Монгол Алтан улстай эн зэрэгцэхүйц өрсөлдөгч хүчин болон гарч ирэхийн тулд бүх Монголыг нэгтгэх, үүний төлөө юуны өмнө Татаар аймгийг байлдан дагуулах ёстой байв. Ийнхүү 70-80 жил үргэлжилсэн урт ужиг тэмцлийн эцэст Хамаг Монгол, түүний тэргүүлэгч Тэмүжин ялан гарч ирсэн юм. Энэ нь 1206 онд Монголын нэгдсэн төр байгуулагдаж, 1234 онд Алтан улсыг байлдан дагуулахын угтвар нөхцөл болсон билээ. Хамаг Монгол-Алтан улсын харилцааны түүх нь монголчууд бүх эсгий туургатныг нэгтгэн Төв Азийн улс гүрний харилцаанд нэгэн биеэ даасан хүч (субъект Ц. Б.) болон гарч ирснийг тодруулахад онц ач холбогдолтой болно.

1. Д. Гонгор Халх Товчоон, боть 1, УБ., 1970, 72-р тал
2. Рашид-ад-Дин. Сборник летописей, том 1., книга вторая, М., 1952, с. 35
3. Монголын нууц товчоо, УБ, 1990, 34-р тал
4. Мэн-да бэй-лу (Полное описание монголо-татар») Пер. с кит. Н. Ц. Мункуева, М., 1975, с. 51

5. Тояма Гунжи. Кинтёши кэнкю (Цзинь улсын түүхийн судлал) Кёто, 1964, 427-428-р тал
6. Рашид-ад-Дин. Сборник летописей, т. 1, кн. 2, с. 35
7. Мөн тэнд с. 36
8. А. Амар, Монголын товч түүх, УБ., 1989, 98-р тал
9. Да Цзинь го чжи-Цз. 12, —с. 132
10. Дальний Восток и соседние территории в средние века, Новосибирск, 1980, с. 147
11. Харамсалтай нь Сипин голыг одоо хүртэл тогтоосон зүйлгүй. А. Амарын бичсэнээр зарим түүхчид Ши Бингэбай гэгч газар Хэрлэнгийн умард этгээд газар мөн хэмээжээ.
12. А. Амар, Монголын товч түүх., УБ., 1989, 98-р тал
13. Да Цзинь го чжи, — Цз. 5 — с. 108
14. Рашид-ад-Дин Сборник летописей, т. 1, кн. 2, с. 33
15. Мөн тэнд с. 41
16. Монголын нууц товчоо, УБ, 1990, 34-р тал
17. Рашид-ад-Дин Сборник летописей, т. 1, кн. 2, 42-р тал
18. Мөн тэнд, с. 43
19. Монголын нууц товчоо. УБ., 1990, 36-38-р тал
20. БНМАУ-ын түүх, тэргүүн боть, УБ., 1966, 179-р тал
21. Мэн-да бэй-лу (Полное описание монголо-татар) М., 1975, с. 70
22. Монголын нууц товчоо, УБ., 1990, 83—84-р тал
23. Чаутхури гэдэг үг аль хэлэнд хамаарагдахыг одоо хүртэл тогтоосонгүй, Чаутхурийг хятадаар хүчит ноён гэсэн үг гэж Рашид-ад-Дин тайлбарлажээ.
24. Монголын нууц товчоо, УБ., 1990, 114-р тал
25. Рашид-ад-Дин Сборник летописей, т. 1, кн. 2, с. 42